МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 6 дугаар сарын 20-ны өдөр | Дугаар 188 | Улаанбаатар хот

ХУУЛЬ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 81, 82 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 28.1, 28.3, Малын генетик нөөцийн тухай хуулийн 10.7, 15.1, Төсвийн тухай хуулийн 10.1.10, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Мал аж ахуйг эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болгон хөгжүүлэх төрийн бодлогын зорилтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний зарим байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагааг уялдуулж, үр ашгийг дээшлүүлэх зорилгоор дараах байгууллагыг улсын төсөвт нөлөө үзүүлэхгүй, орон тоо нэмэхгүйгээр төсвийн багцдаа зохицуулалт хийж, өөрчлөн байгуулсугай:

1.1. "Малын удмын сангийн үндэсний төв" аж ахуйн тооцоот улсын үйлдвэрийн газрыг малын үндэсний генийн санг хамгаалах, сайжруулах үндсэн чиг үүрэг бүхий "Малын удмын сангийн үндэсний төв" улсын төсөвт үйлдвэрийн газар болгон өөрчлөн зохион байгуулж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны харьяанд ажиллуулах;

1.2. **"Улсын мал эмнэлэг, ариун цэвэр, эмийн сорилт, баталгаажуулалтын нэгдсэн лаборатори"** улсын төсөвт үйлдвэрийн газрыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Мал эмнэлгийн ерөнхий газрын харьяанд ажиллуулах.

(Энэ хэсэгт Засгийн газрын 2025 оны 153 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон)

2. "Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв" аж ахуйн тооцоотой улсын үйлдвэрийн газар, "Биокомбинат" аж ахуйн тооцоотой улсын үйлдвэрийн газар, "Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори" аж ахуйн тооцоотой улсын үйлдвэрийн газрыг тус тус татан буулгасугай.

3. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд "Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв" улсын төсөвт үйлдвэрийн газрыг байгуулсугай.

~~4. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Мал эмнэлгийн ерөнхий газрын харьяанд "Биокомбинат" улсын төсөвт үйлдвэрийн газар, "Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори" улсын төсөвт үйлдвэрийн газрыг тус тус байгуулсугай.~~

(Энэ зүйлд Засгийн газрын 2019 оны 186 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон. Засгийн газрын 2025 оны 153 дугаар тогтоолоор хүчингүй болгосон)

5. Зарим байгууллагыг татан буулгаж, шинээр байгуулсантай холбогдуулан хууль тогтоомжийн дагуу комисс томилж, татан буугдсан байгууллагуудын эд хөрөнгөд тооллого хийж, хаалтын тайлан баланс гаргаж, үндсэн болон бусад эд хөрөнгийг шинээр байгуулагдах хуулийн этгээдэд шилжүүлэх арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзориг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т тус тус даалгасугай.

6. Дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзоригт даалгасугай:

6.1. энэ тогтоолын 3, 4 дэх хэсэгт заасан байгууллагуудын дүрэм, зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг батлагдсан орон тоо, төсөвтөө багтаан мөрдүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах;

6.2. шинээр байгуулагдсан байгууллагуудын бизнес төлөвлөгөө, төсвийг баталж, үйл ажиллагаанд нь хяналт тавих.

7. Малын удмын сангийн үндэсний төв болон орон нутаг дахь цэм сүргийн салбар, нэгжийн үйл ажиллагааг эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагатай уялдуулах, эрдэмтэн, судлаачдын судалгааны үр дүн, дэвшилтэт технологи, арга зүй, санал санаачлагыг бүтээлчээр ашиглах замаар мал сүргийн чанарыг шинжлэх ухааны үндэстэйгээр сайжруулах, ашиг шимийг нэмэгдүүлэх, Малын удмын сангийн үндэсний төвийн үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзоригт үүрэг болгосугай.

8. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Төсвийн байгууллагуудад хийх бүтэц, зохион байгуулалтын зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2015 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн 55 дугаар тогтоолын 3 дахь хэсгийн 4, 5 дахь "Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори" заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

9. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Малын удмын сангийн үндэсний төв, цэм сүргийн үржлийн төв байгуулах тухай" Засгийн газрын 2006 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн 172 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД У.ХҮРЭЛСҮХ

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД Б.БАТЗОРИГ